

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019 оны 3 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар ...ХЭХТ/01

Улаанбаатар хот

“ЛЭНДМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 3 дугаар сарын 23-ний өдөр, 12.00 цагаас Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Корпорейт Конвеншн центр, Эвент танхимд зохион байгуулав. 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 800,000,000 ширхэг хувьцаа эзэмшдэг 3904 хувьцаа эзэмшигчдээс 167 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн нь 628,811,499 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрх бүхий хувьцааны 78,6% болж байх тул Компанийн тухай хуулийн 69.1-т зааснаар ХЭХ хуралдуулах ирц бүрдэж хурал хүчин төгөлдөр болсныг тооллогын комиссын дарга М.Түвшинжаргал зарлав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ:

1. Хэлэлцэх асуудлыг батлах;
2. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
3. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, сонгох тухай;
5. Компанийн ТУЗ-ийн 2019 оны төсвийн саналыг танилцуулах;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулах;
7. Компанийн хувьцаа халааслах саналыг танилцуулах;
8. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт;
9. Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах;
10. Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолуудыг батлах.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурал:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг танилцуулах: Тооллогын комиссын дарга М.Түвшинжаргал
 - а. ХЭХ-ийн ирцийг танилцуулья.
Ирц: 3904 хувьцаа эзэмшигчдээс 167 хувьцаа эзэмшигч ирсэн, Нийт саналын 78.6 хувь болж байгаа тул КтХ-ийн дагуу ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болж байна.
2. Хурал нээх
 - а. О.Болдбаатар: Ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах ирц бүрдсэн тул ХЭХ-ийг нээснийг мэдэгдье.
3. Хурлын дэгийг танилцуулав.
 - i. 2018 оны үйл ажиллагааны болон аудитын тайланг танилцуулах;
 - ii. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - iii. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах;
 - iv. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, сонгох тухай;

- v. Компанийн ТУЗ-ийн 2019 оны төсвийн саналыг танилцуулах;
- vi. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулах;
- vii. Компанийн хувьцаа халааслах саналыг танилцуулах;
- viii. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт;
- ix. Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах;
- x. Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолуудыг батлах;
- xi. Хурлыг хаах.

4. Хэлэлцэх асуудлыг батлах

Танилцуулсан нь: Хурлын дарга О.Болдбаатар

Тайлбар: Хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

5. Хэлэлцэх асуудал 1: 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан.

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Б.Гантулга

- 2018 оны үйл ажиллагааг тайлагнасан видеог танилцуулав.

2017 оны сүүлээр нийт активын хэмжээ 7.1 тэрбум төгрөг байсан бол 2018 онд 24.3 тэрбум төгрөг болсон байна.

6. Хэлэлцэх асуудал 2: Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,

2018 оны санхүүгийн тайланг батлах эсэх тухай

Танилцуулсан нь: Хурлын дарга О.Болдбаатар

Тайлбар: ТУЗ-ийн 2019.1.30-ны хурлаар Эрнст Энд Янг Монголиа Аудитын компанийн гаргасан хангалттай гэсэн дүгнэлтийг ТУЗ-өөс хүлээн зөвшөөрч, 2018 оны үйл ажиллагааны тайланг хангалттай гэж дүгнэлт гаргасан. Энэхүү дүгнэлтийг батлахыг Хувьцаа эзэмшигч та бүхнээс санал хураахаар ийнхүү оруулж байна.

7. Хэлэлцэх асуудал 3: Компанийн ТУЗ-ийн гишүүнд шинээр нэр дэвшигчдийг танилцуулах;

Танилцуулсан нь: ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дарга В.Баярсайхан

Тайлбар: ХЭХ-д идэвхитэй оролцож байгаа та бүхэнд баяр хүргэе. ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны танилцуулгын талаар танилцуулах видеог хүргүүлж байна. 2018 оны Компанийн төлөөлөн удирдах зөвлөл 4 удаа ээлжит байдлаар хуралдаж, 4 удаа эчнээ байдлаар хуралдсан байна.

Ердийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг видео хэлбэрээр танилцуулав.

Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг видео хэлбэрээр танилцуулав.

В.Баярсайхан: ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн 40 орчим материал ирсэнээс 7 хүнийг сонгон шалгаруулж ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчээр танилцуулж байна.

8. Хэлэлцэх асуудал 4: Компанийн ТУЗ-ийн 2019 оны төсвийн саналыг танилцуулах

Танилцуулсан нь: Хурлын дарга О.Болдбаатар

Тайлбар: Өнгөрсөн жилийн ТУЗ-ийн төсөвтэй ижил, гишүүд болон ТУЗ-ийн даргын цалин адилхан байхаар гэхдээ ТУЗ-ийн хурлыг жилд 5 удаа байхаар төсвийн саналыг оруулж байна.

9. Хэлэлцэх асуудал 5: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулах;

Танилцуулсан нь: Хурлын дарга О.Болдбаатар

5.1. Компанийн дүрэмд оруулах эхний өөрчлөлт нь манай компани үйл ажиллагаагаа тэлж, ажиллах хүчний тоо ихэссэн тул өөр оффисын байрлуу нүүсэн. Иймд компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлүүлэхээр ийнхүү дүрмийн заалтыг өөрчлөх саналыг хүргүүлж байна.

5.2. Компанийн үйл ажиллагааны чиглэл нэмэгдэж байгаа тул ийнхүү шинээр нэмэгдэж буй үйлчилгээний чиглэл бүрийг нэмж дүрэмд өөрчлөлт оруулахаар энэхүү дүрмийн нэмэлт өөрчлөлтийн саналыг оруулж байна. Та бүхний вэбээр өгөх саналын хуудасны текст дээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу хуулиар зөвшөөрөгдөх тусгай зөвшөөрөлтэй бүх үйл ажиллагааны чиглэл орсон байгаа. Энэхүү текст нь өөрчлөгдсөн тул та бүхэнд тараасан хувьцаа эзэмшигчдийн хурлын материалын 49 дүгээр хуудаст заагдсан агуулгаар санал хураалт явагдахыг мэдэгдэж, хурлын тэмдэглэлд тусгуулж байна. Өөрөөр хэлбэл вэбээр авах санал хураалтын текстийн агуулгаар бус тараах материалын 49 дугаар хуудаст заасан агуулгаар санал хураалт явагдахыг мэдэгдье.

5.3. Компанийн дүрмийн 9.6.22 дахь заалт буюу ТУЗ-ийн бүрэн эрхэд “Компани нь энэхүү дүрмийн 4.2.6 дахь заалтад заасан Санхүүгийн Зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу эрхлэх Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх эсэх асуудлыг бие даан шийдвэрлэх” гэж нэмэх, үүнтэй холбоотойгоор Дүрмийн одоогийн 9.6.22 дахь заалтын дугаарыг “9.6.23” болгож өөрчлөх тухай санал хураалт явагдана.

10. Компанийн хувьцаа халааслах саналыг танилцуулах;

Танилцуулсан нь: Хурлын дарга О.Болдбаатар

Дэлхийн болон МУ-ын томоохон компаниудын жишгийг даган сайн ажилласан, болон бусад байдлаар компанийнхаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн, амжилт үзүүлж буй ажилчиддаа урамшуулал олгох зорилгоор урамшууллын бодлого хэрэгжүүлэхээр 4 сая ширхэг хувьцааг халааслах саналыг оруулж байна. Энэхүү халааслах ажиллагааг зөвхөн дээрх зорилгын дагуу зарцуулахаар эргүүлэн худалдаж авч байна.

11. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт; Асуулт асууж, хариулт өгөв.

12. Санал хураалтын дүнг танилцуулах

Танилцуулсан нь: Тооллогын комиссын дарга М.Түвшинжаргал

Тайлбар: Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын дүнг танилцуулахаар ийнхүү гарч ирэв. Танилцуулаад, тогтоолын төслийг уншиж танилцуулав. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай санал хураалтын дүн:

- 1.1. Зөвшөөрсөн 628,807,661 ширхэг 100%;
 - 1.2. Татгалзсан 3,838 ширхэг 0%;
 - 1.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсвийг батлах тухай санал хураалтын дүн:
 - 2.1. Зөвшөөрсөн 628,708,075 ширхэг 100%;
 - 2.2. Татгалзсан 9,416 ширхэг 0%;
 - 2.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
3. Компанийн дүрмийн 2.2-т “Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34 хаягт байрлах Сувд төв, 1 болон 2 тоот” гэж өөрчлөлт оруулах тухай санал хураалтын дүн:
 - 3.1. Зөвшөөрсөн 628,717,491 ширхэг 100%;
 - 3.2. Татгалзсан 0 ширхэг 0%;
 - 3.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 17.1 дэх хэсэгт зааснаар санал хураалт хүчинтэй.
4. Дүрмийн 4.2 дахь заалтын “Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд: 4.2.1.Зээлийн үйл ажиллагаа; 4.2.2.Төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулинд заасан бусад төрлийн үйл ажиллагаа; 4.2.3.Хуулиар хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа” гэснийг “Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд: 4.2.1. Зээл; 4.2.2. Факторингийн үйлчилгээ; 4.2.3. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; 4.2.4. Гадаад валютын арилжаа; 4.2.5. Итгэлцлийн үйлчилгээ; 4.2.6. Төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулинд заасан бусад төрлийн үйл ажиллагаа; 4.2.7. Хуулиар хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа” гэж тус тус өөрчлөх. тухай санал хураалтын дүн:
 - 4.1. Зөвшөөрсөн 628,242,482 ширхэг 99,93%;
 - 4.2. Татгалзсан 452,556 ширхэг 0,07%;
 - 4.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 17.1 дэх хэсэгт зааснаар санал хураалт хүчинтэй.
5. Дүрмийн 9.6.22 дахь заалтад “Компани нь энэхүү дүрмийн 4.2.6 дахь заалтад заасан Санхүүгийн Зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу эрхлэх Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх эсэх асуудлыг бие даан шийдвэрлэх” гэж нэмэх. Үүнтэй холбоотойгоор Дүрмийн одоогийн 9.6.22 дахь заалтын дугаарыг “9.6.23” болгож өөрчлөх.тухай санал хураалтын дүн:
 - 5.1. Зөвшөөрсөн 628,694,038 ширхэг 100%;
 - 5.2. Татгалзсан 0 ширхэг 0%;
 - 5.3. Түдгэлзсэн 1,000 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 17.1 дэххэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

6. Компанийн нийт гаргасан хувьцааны 0.5%-тай тэнцэх буюу 4,000,000 (дөрвөн сая) ширхэг хувьцааг Гүйцэтгэх удирдлагын болон ажиллагчдад зориулсан дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор халааслан, эргүүлэн худалдан авах тухай санал хураалтын дүн:

6.1. Зөвшөөрсөн 628,627,615 ширхэг 99,99%;

6.2. Татгалзсан 59,813 ширхэг 0.01%;

6.3. Түдгэлзсэн 7,610 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

7. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

7.1. Очирсүрэнгийн БОЛДБААТАР 631,470,955 ширхэг буюу 16,82%-ийн санал;

7.2. Володьегийн БАЯРСАЙХАН 627,517,998 ширхэг буюу 16,71%-ийн санал;

7.3. Баянжаргалын ДЭЛГЭРЖАРГАЛ 624,496,192 ширхэг буюу 16,63%-ийн санал;

7.4. Нармандахын ЦЭВЭГМИД 625,737,863 ширхэг буюу 16,66%-ийн санал;

7.5. Сэнгээгийн ЭНХ-АМГАЛАН 621,948,053 ширхэг буюу 16,56%-ийн санал;

7.6. Мэтью ВЭЛЧ 624,201,405 ширхэг буюу 16,62%-ийн санал;

байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэг, СЗХ-ны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д зааснаар шийдвэр хүчинтэй.

8. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

8.1. Чинбатын НОМИН 626,614,806 ширхэг буюу 33,38%-ийн санал;

8.2. Сүрэнхүүгийн БОРГИЛ 628,329,874 ширхэг буюу 33,47%-ийн санал;

8.3. Жигдэнгийн ЖАРГАЛСҮРЭН 613,299,459 ширхэг буюу 32,67%-ийн санал;

8.4. Чимэдийн ОЧ 1,948,467 ширхэг буюу 0,1%-ийн санал;

8.5. Баярсайханы ТАМИР 1,793,044 ширхэг буюу 0,1%-ийн санал;

8.6. Чадраабалын БАЯНЖАРГАЛ 295,455 ширхэг буюу 0,02%-ийн санал;

8.7. Ядамсүрэнгийн ӨЛЗИЙБОЛД 5,213,134 ширхэг буюу 0,28%-ийн санал байх тул Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэг, СЗХ-ны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д зааснаар шийдвэр хүчинтэй.

13. Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хурлын тогтоолыг батлах

Танилцуулсан нь: Хурлын дарга О.Болдбаатар

Тайлбар: Тооллогын комиссын дээрх дүгнэлтийг үндэслэн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол тус бүрийг уншин танилцуулж батлав.

Ийнхүү хурлын дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хаасныг мэдэгдэв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын албан ёсны хэсэг өндөрлөв.

Үүний дараа Гүйцэтгэх захирал Б.Гантулга Компанийн 2019 оны Үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, мэдээлэл өгөв.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:

ЛЭНДМН ББСБ ХК

.....О.БОЛДБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

УЛААНБААТАР ХОТ

5019/2019

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:О.МӨНХДӨЛГӨӨН